



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:	2024 оны 7 дугаар сарын 8
Зээлийн дугаар ба нэр:	ЗЭЭЛ 3694-MON(OCR): Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл
Гэрээний дугаар ба нэр:	BYW.CW3-001: Баянхошуу дэд төвийн В-13/1 болон В-13/2 талбарын инженерийн байгууламж, салбар шугам сүлжээний ажил
Тендер хүлээн авах эцсийн огноо ба цаг:	2024 оны 8 дугаар сарын 12-ний өдөр 15:00 цаг /Улаанбаатарын цагаар/

1. Монгол Улс Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх)-наас **Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төслийг** хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурьдсан гэрээний хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.
2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь (цаашид “захиалагч” гэх) эрх бүхий тендерт оролцогчдоос **BYW.CW3-001: Баянхошуу дэд төвийн В-13/1 болон В-13/2 талбарын инженерийн байгууламж, салбар шугам сүлжээний ажил** (цаашид “ажил гэх”) гүйцэтгэх битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
3. Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулна.
4. Зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендерт оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно. Үүнд:
 - Барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрлүүдтэй байх. Үүнд: **БХБЯ-ны тусгай зөвшөөрөл:**
Багц-1: БА-6.1; БА-6.2;
Багц-2: БА-2.1; БА-3.5; БА-6.3; БА-6.4, эсхүл Эсхүл Эрчим хүчний яамны 03.2.1 заалт, 0.4-10кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний тусгай зөвшөөрөл дээрх заалтуудтай дүйцэнэтусгай зөвшөөрөлтэй дүйцэхүйц;

- Сүүлийн 5 жилд (2019, 2020, 2021, 2022, 2023 онуудад) амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд үндсэн гүйцэтгэгч, түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгчийн хувиар оролцсон байх, ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь **Багц 1-д 1.1 тэрбум, Багц 2-т 1.4 тэрбум** төгрөгөөс доошгүй байна. Тендерт оролцогчийн гүйцэтгэсэн ажлын ижил төстэй байдлыг Зургаадугаар бүлэг (Тодорхойлолт ба бусад шаардлага)-т тодорхойлсны дагуу тухайн ажлын биет хэмжээ, онцлог чанар, иж бүрдэл, арга барил, технологи болон бусад шинжид үндэслэн тодорхойлно.
 - Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлагын доод хэмжээ:

Багц-1: i) Дунд төвөгшилтэй дулаан хангамж, хэрэглээний халуун ус хангамжийн шугам сүлжээний ажил гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан туршлагатай байх; ii) Дунд төвөгшилтэй ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж, байнгын ашиглалтад оруулсан туршлагатай байх;

Багц-2: i) Дор хаяж 2х800кВА чадалтай 10/0.4кВ хаалттай дэд өртөөний барилгыг иж бүрэн тоноглолын хамт барьж, 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам татаж байнгын ашиглалтад оруулсан туршлагатай байх; ii) Гадна холбооны сувагчлал, шилэн кабелийн угсралтыг хийж байнгын ашиглалтад оруулсан туршлагатай байх;
 - Сүүлийн 5 жилд (2019, 2020, 2021, 2022, 2023 онуудад) хэрэгжиж дууссан эсхүл хэрэгжиж байгаа гэрээт ажлын хүрээнд хүлээн авсан баталгаат төлбөрийн нийт дүнгээр тооцсон барилгын ажлын борлуулалтын доод хэмжээ нь эдгээр жилүүдээс дурын 3 жилийн дунджаар тооцсоноор **Багц 1-д 1.9 тэрбум, Багц 2-т 2.3 тэрбум, Багц 1 ба Багц 2-т хамтад нь тендер ирүүлэх бол 4.2 тэрбум төгрөгөөс доошгүй байх;**
 - Энэ гэрээнд шаардагдах санхүүгийн нөөц хөрөнгө нь **Багц 1-д 490.0 сая, Багц 2-т 590.0 сая,** Багц 1 ба Багц 2-т хамтад нь тендер ирүүлэх бол **1.0 тэрбум төгрөгөөс доошгүй** байна.
5. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Захиалагч : Нийслэлийн засаг даргын тамгын газар
Харилцах ажилтан : ТХН-ийн худалдан авах ажиллагааны мэргэжилтэн
Гудамж : Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Чингисийн Өргөн чөлөө -8, Экспресс тауэр
Давхар/өрөөний дугаар : 14 давхар, 10 тоот
Хот : Улаанбаатар хот
Улс : Монгол улс
Утас : +976 77770024, +976 77770023
Факс : +976 77770024
Цахим шуудангийн хаяг : procurement@mub-ahurp.mn

6. Эрх бүхий тендерт оролцогч тендерийн баримт бичгийг худалдан авахыг хүсвэл:

- “**ВҮW.CW3-001: Баянхошуу дэд төвийн В-13/1 болон В-13/2 талбарын инженерийн байгууламж, салбар шугам сүлжээний ажил**”-ын тендерийн баримт бичиг авах хүсэлтийг дээр хаягийн дагуу бичгээр ирүүлнэ.
- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дараах дансанд **50,000 төгрөгийг** буцаан үл олгогдох хураамжийг төлсөнөөр Тендерийн баримт бичгийг худалдан авч болно.
 - Дансны нэр: Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл
 - Банкны нэр: Төрийн сан
 - Дансны дугаар (Төг/MNT): 100900011969

7. Тендерийг дээр дурдсан хаягаар

- Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө: **2024 оны 8 дугаар сарын 12-ний өдрийн 15:00 цаг**
- Тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерийн нээлтэд оролцохыг хүссэн эрх бүхий оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.